

# МОНГОЛ УЛС

## БОДЛОГО БОЛОВСРУУЛАГЧДАД ЗОРИУЛСАН ХУРААНГУЙ

Гамшиг, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс  
хүн ам, амьжиргааг хамгаалах чадавхыг  
сайжруулах тухай гол зөвлөмжүүд

2024 он



КАДРИ (CADRI-Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх түншлэл) нь Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд гамшгийн болон уур амьсгалын эрсдэлийг бууруулах зорилгоор улс орнуудын харилцан уялдаатай, нэгдсэн шийдлүүдийг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн НҮБ-ын тэргүүлэл бүхий дэлхийн түншлэл, хамтын ажиллагаа юм.

Энэхүү хэвлэмэл материалыг мэдлэг, мэдээлэл олгох болон арилжааны бус бусад зорилгоор зохиогчийн эрх эзэмшигчийн тусгай зөвшөөрөл авалгүйгээр бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ямар ч хэлбэр, хэрэгслээр ашиглах, хуулбарлах боломжтой. Нэгдсэн Үндэстний Байгууллага уг баримт бичгийг ашигласан аливаа хэвлэмэл материалын хуулбарыг хүлээн авахдаа талархах болно.

2023 онд зохион байгуулагдсан Монгол Улсын гамшгийн болон уур амьсгалын эрсдэлийг удирдах үндэстний ба орон нутгийн чадавхын үнэлгээний үр дүн, зөвлөмжийг тус тайланд тусган танилцуулж байна. Үнэлгээнд 2024 оны эхэн үеийн техникийн шинэчлэгдсэн мэдээллүүдийг нэмж тусгасан болно.

© Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх түншлэл, 2024 он

Эх бэлтгэсэн: Карен Ачиенг

Монгол Улсын уур амьсгалын болон гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг 2023 оны 9 дүгээр сард нарийвчлан үнэлсэн. Уг үнэлгээгээр давуу талууд болон сайжруулах шаардлагатай асуудлуудын аль алиныг тодорхойлохыг зорьсон юм. Түүнчлэн нийгэм, эдийн засгийн амин чухал салбаруудын хүрээнд эрт зарлан мэдээлэх систем, гамшгийн бэлэн байдал, эрсдэлийг бууруулах стратегийг сайжруулах чиглэлээр практик зөвлөгөө өгөхөд анхаарал хандуулсан болно. Үнэлгээний гол үр дүн, зөвлөмжүүдийг энэхүү баримт бичигт нарийвчлан тусгалаа. Үнэлгээг Онцгой байдлын ерөнхий газар, НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын удирдлага дор Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх (КАДРИ) түншлэлийн оролцоотой гүйцэтгэв.

Зөвлөмж тус бүрийн хэрэгжүүлэх байдал, холбогдох зардлыг дараах хэлбэрээр тэмдэглэн харуулсан болно.

### Хэрэгжүүлэх байдал

- Хялбар
- ● ● Төвөгтэй

### Зардал

- Бага зардал
- ● ● Их зардал

## БОДЛОГО БОЛОВСРУУЛАГЧДАД ЗОРИУЛСАН ХУРААНГУЙ

Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг, КАДРИ үнэлгээний хэмжүүрүүдийн дагуу гамшгийн болон уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тогтолцооны чадавхыг үнэллээ. КАДРИ үнэлгээ, төлөвлөлтийн аргачлал нь үндэсний болон орон нутгийн түвшний засаглал, хэрэгжүүлэх чадавх, санхүүжилт, мэдлэг мэдээлэл, технологийг үнэлэх зорилгоор боловсруулсан модуль асуумж, хагас бүтэцлэгдсэн ярилцлага, мэдээллийн дүн шинжилгээнээс бүрддэг.

### ҮНЭЛГЭЭНИЙ ГОЛ ЧИГЛЭЛҮҮД

- Бэлэн байдал
- Эрт зарлан мэдээлэл
- Эрсдэлийг бууруулах ажиллагаа

### САЛБАРУУД

- Хөдөө аж ахуй
- Байгаль орчин
- Дэд бүтэц (үерийн хамгаалалт, сургууль, эмнэлгийн барилга байгууламж,
- эрчим хүчний дэд бүтцийн бэлэн байдал)
- Нийгмийн хамгаалал
- Хүн амын шилжилт хөдөлгөөн

Чадавхын үнэлгээг Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ), НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын удирдлага дор ОБЕГ, НҮБ-ын Хүн амын сан, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, НҮБ-ын Гамшгийн үнэлгээ, зохицуулалтын газар, НҮБ-ын Хабитат байгууллага, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар, Дэлхийн зөн, Дэлхийн цаг уурын байгууллага (БНХАУ, БНСУ-ын цаг уурын мэргэжилтнүүд), КАДРИ түншлэлийн нарийн бичгийн дарга нарын газрын буюу үндэсний болон олон улсын нийт 16 мэргэжилтнээс бүрдсэн баг хамтран гүйцэтгэлээ.

Чадавхын үнэлгээнд КАДРИ дижитал арга хэрэгслийг ашигласан бөгөөд төрийн байгууллагуудын 100 гаруй төлөөлөгч, иргэний нийгмийн 7, хувийн хэвшлийн 2 байгууллага болон орон нутгийн 120 гаруй хүн хамрагдсан болно. Засаглал, хэрэгжилт, санхүүжилт, мэдлэг мэдээлэл, технологийн чиглэлээр зөвлөмж гаргаж, түүнийгээ хэрэгцээ шаардлага, хэрэгжүүлэх байдал, төсвийн хувьд эрэмбэллээ.



Фото зураг: Монгол Улс/НҮБХХ

## УУР АМЬСГАЛ, ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улс нь ОХУ, БНХАУ-тай хиллэдэг, уул нуруу, говь цөл бүхий 1.5 сая хавтгай дөрвөлжин газар нутгаараа дэлхийд 19 дүгээрт ордог, Зүүн Азийн далайд гарцгүй орон юм. Нийт 3.4 сая хүн амтай бөгөөд хүн амын 69% нь хот суурин газарт, үүний 48% нь нийслэл Улаанбаатар хотод оршин суудаг. Монгол орны хүн амын 36%-ийг хүүхэд, залуучууд, 3%-ийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна. Уламжлалт мал аж ахуй, газар тариаланд суурилсан эдийн засгаас олборлох үйлдвэрлэлд суурилсан эдийн засагт шилжиж байгаа Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн зуд, шороон шуурга зэрэг байгалийн гамшгууд тохиолддог. 2015 оноос хойш уур амьсгалын гаралтай аюулт үзэгдэл, ослын давтамж 2.9 дахин өссөн бөгөөд 2024 оны эрсдэлийн удирдлагын ИНФОРМ индексээр 116 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

Монгол орны уур амьсгал сүүлийн 80 жилд мэдэгдэхүйц дулаарч, гадаргын температур 2.25°C-аар ихсэн хүйтэн өдрийн тоо цөөрч, халуун өдрийн тоо нэмэгдсэн байна. Уулархаг бүс нутагт илүү тод ажиглагдаж буй энэхүү дулаарал нь усны нөөцийг багасгаж, хур тунадасны хэв маягийг өөрчилснөөр

экологийн тэнцвэрт байдал алдагдаж, ургамал хомсдон биологийн төрөл зүйл, газар тариалангийн уламжлалт зан үйлд аюул учирч байна. Цаашид өвлийн улиралд орох хур тунадас нэмэгдэх боловч зун орох хур тунадас өөрчлөгдөхгүй, 2030 он гэхэд хуурайшилт илүү нэмэгдэн хуурай болон хуурайвтар бүс нутгийн хэмжээ ихсэх, чийглэг бүс нутгийн хэмжээ багасах хандлагатай байна.

Уур амьсгалын дулаарал нь мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг хүн амд ихээхэн нөлөө үзүүлж, эрсдэлийн тооцоо төлөвлөлтгүй хотжилт нь газар хөдлөлт зэрэг геологийн гаралтай аюулын эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настантай малчин өрхүүд өвлийн хүнд хэцүү цагт отор нүүдэл хийх боломж муутай байдгаас уур амьсгалын нөлөөлөлд улам бүр эмзэг байдалтай болжээ. Уур амьсгалын өөрчлөлт нь ялангуяа ядуу гэр бүл, өрх толгойлсон эмэгтэйчүүд, өндөр настан, хүүхдүүдийн үйлчилгээ авах, нөөцөд хүрэх боломжийг хязгаарласнаар тэгш бус байдал улам бүр нэмэгдэнэ гэж үзэж байна. Сүүлийн жилүүдэд үндэсний хэмжээнд ядуурлын түвшин бага зэрэг буурч, хөдөө орон нутагт байдал илүү сайжрах хандлагатай байна. Зуд, үер зэрэг уур амьсгалын гаралтай гамшгийн улмаас хүүхдүүдийн сургуульдаа явах, сурч боловсроход хүндрэл учирдаг ажээ.



## ЗАСАГЛАЛ

Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) нь 2004 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Шадар сайдын удирдлага дор ажиллаж, гамшгийн эрсдэлийн удирдлагыг хууль эрх зүй, бүтэц, зохион байгуулалтын тогтвортой хүрээнд буюу гамшгийн бэлэн байдал, салбар хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааг хангах зорилготой Улсын онцгой комисс, Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл гэсэн үндсэн хоёр бүтцэд түшиглэн хэрэгжүүлж байна. Монгол Улс гамшгийн эрсдэлийг бууруулах хүчин чармайлтаа дэлхийн стратегид нийцүүлж, Йокохамагийн стратегиас Хёгогийн хүрээгээр дамжин Сендайн үйл ажиллагааны хүрээнд шилжиж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэхээр тусгажээ. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний

хөтөлбөр нь энэхүү бодлогод нийцэн хоёр үе шаттайгаар (2015-2020, 2021-2025) хэрэгжиж байна.

ОБЕГ-ын газар, хэлтсүүдийн үйл ажиллагааны өнөөгийн бүтэц нь гамшгийн дараах сэргээн босгох, сэргээн засварлах ажиллагаанд хяналт тавих үүрэг хариуцлагад нийцэхгүй байгаа нь эдгээр үе шатыг зохицуулах бодлогын тогтолцоо, бэлэн байдал дутмаг байгааг харуулж байна. Түүнчлэн гамшгийн болон уур амьсгалын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх нь нийгэм, эдийн засгийн олон салбарын нэн чухал үүрэг боловч яам, агентлагууд, орон нутгийн засаг захиргаанд эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх чадварлаг боловсон хүчин, стратегийн төлөвлөгөө, төсөв зэрэг шаардлагатай нөөц байхгүй байна.

### НЭН ЧУХАЛ, ТҮҮВЭР ЗӨВЛӨМЖҮҮД:

1.

Үер, зуд, газар хөдлөлт, хүчтэй салхи, шуурга, гал түймэр зэрэг зонхилон тохиолддог гамшгийн төрлүүдээр, гамшгийн эрсдэлийн удирдлагын үе шат (гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох/сэргээн засварлах, эрсдэлийг бууруулах, бэлэн байдал) бүрээр салбарын яамд, агентлагуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгосон удирдамж боловсруулах.



2.

i) Эрсдэлийн талаарх мэдлэг, мэдээлэл; ii) илрүүлэх, ажиглах, хяналт тавих, дүн шинжилгээ хийх, урьдчилан таамаглах; iii) сэрэмжлүүлгийг хүргэх, мэдээлэх; iv) хариу арга хэмжээ авах бэлэн байдал гэсэн үндсэн дөрвөн асуудлыг багтаасан, хүн амд шууд хүрэх, аюулын эрт зарлан мэдээлэх системийг сайжруулах бодлого, төлөвлөгөөг (богино, дунд, урт хугацааны) боловсруулах.



3.

ОБЕГ-ын дотоод чиг үүрэг, газар, хэлтсүүдийн үүрэг хариуцлагыг сайтар судалж, давуу тал, хүний нөөцийг оновчтой хуваарилж, бие биенээ нөхөн ажиллах боломжтой болгох.



## МЭДЛЭГ МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИ

Монгол Улс нь аюул, өртөх байдал, эмзэг байдлын талаар мэдлэг, мэдээллийн суурь сайтай бөгөөд боломжит технологиудыг үр дүнтэй ашиглах чадавхтай. Аюулт үзэгдлүүд, учирч байсан хохирлын талаарх түүхэн мэдээлэл, өртөх байдлын талаарх өгөгдөл мэдээ нь гамшгийн эрсдэлийг бууруулах урт хугацааны стратеги, эрт зарлан мэдээлэх систем, хариу арга хэмжээний бэлтгэл, бэлэн байдлыг удирдан чиглүүлэхэд хангалттай. Эрсдэлийн үнэлгээний нарийвчлалыг сайжруулах, цаг агаарын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээг боловсронгуй болгох, техник технологи, тоног төхөөрөмжийг шинэчлэх, засвар үйлчилгээ хийхэд хөрөнгө оруулах чиглэлээр цаашид үргэлжлүүлэн ажиллах нь зүйтэй.

Монгол Улсад ажиглалтын сүлжээг өргөжүүлэн ус, цаг уурын гаралтай аюулын хяналтыг сайжруулахаар ажиллаж байгаа боловч мэдээ авах давтамж болон мэдээллийн нарийвчлал хангалтгүй байх зэрэг хүндрэлүүд гарч байна. Олон улсын хиймэл дагуулын хамрах хүрээнд Монгол

Улс ихэнхдээ ордоггүй бөгөөд орон нутагт хийгдэж буй ажиглалтын чанарт талбайн нөхцөл байдал, тоног төхөөрөмжийн элэгдэл, засвар үйлчилгээний боломж зэрэг нь нөлөөлж байна. Цаг агаарын богино хугацааны урьдчилсан мэдээ нь техникийн болон тооцооллын хэрэгсэл хангалтгүйгээс цаг хугацаа, орон зайн нарийвчлал муутай байна. Үүнээс гадна газар хөдлөлтийг илрүүлээд мэдэгдэх хүртэлх хугацаа 3 минут орчмын хоцрогдолтой байгаа нь хариу арга хэмжээг үр дүнтэй болгоход харьцангуй удаан юм. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийн дуут дохионы цамхаг, телевиз, радио станцууд, цахим дэлгэцийн самбарууд хуучирч, тоо нь цөөрч байна. Түүнчлэн хөдөөгийн хүн ам болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, хүүхдүүд, гадаадын иргэд зэрэг мэдээллийн хүртээмж багатай эмзэг бүлгийг мэдээллээр хангахад ихээхэн учир дутагдалтай байна. Олон талын төлөөлөлтэй зөвлөлдөх уулзалтууд хийх үед аливаа аюулт үзэгдлийн талаар сэрэмжлүүлээд зогсохгүй, тохиолдохоос нь өмнө бэлтгэх, хэрэгжүүлэх боломжтой алхмуудын талаар мессеж илгээн зааварчилгаа өгөх шаардлагатайг онцлон тэмдэглэж байв.

### НЭН ЧУХАЛ, ТҮҮВЭР ЗӨВЛӨМЖҮҮД:

1.

Цаашид нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ боловсруулах, дэвшилтэт, нарийвчлал сайтай тоон урьдчилсан мэдээ, загварчлалыг хэрэгжүүлэх өндөр хүчин чадалтай тооцооллын системийг нэвтрүүлэх.



2.

Цахим мэдээ, дуут дохио зэрэг шууд мэдээллээр шуурхай хангах ажлыг сайжруулах. Дэлхийн цаг уурын байгууллагаас баталсан үүрэн холбооны сүлжээг ашиглах аргад үндэслэн эрсдэлийн бүсээр текст мессежийг илгээх төлөвлөгөө гаргах.



3.

Яам, агентлагууд гамшгийн талаарх мэдээллийг салбар хооронд нэгтгэх, ойлгох, удирдахын тулд шинэ платформ бий болгохоосоо өмнө одоо байгаа эрсдэлийн мэдээллийн платформуудыг ашигладаг байх нөхцөлийг бүрдүүлэх. Олон нийтийн системүүд хоорондын нийцлийг хангах, хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэхийн тулд систем, мэдээллийн сангийн бүтэц болон бусад тогтолцоог стандартчилах салбар/яам хоорондын механизмыг ашиглахыг зөвлөмж болгож байна.



## ХЭРЭГЖИЛТ

Ихэвчлэн хүний нөөцийн ур чадвар, санхүүгийн боломжоос шалтгаалж эрсдэлийг бууруулах бодлого, бодит гүйцэтгэлийн хооронд зөрүү үүсэн гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаа доголддог. Салбарын яам, агентлагууд гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратегийг хэрэгжүүлэх техникийн мэдлэг, мэдээлэлтэй байсан ч санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх асуудал бэрхшээлтэй хэвээр байна. Нөгөө талаас, ОБЕГ, орон нутгийн ОБГ зэрэг байгууллагууд, нөөц хуваарилах эрх бүхий орон нутгийн удирдлага, албан тушаалтнууд гамшгийн эрсдэлийг

бууруулах эсвэл уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээний хэрэгцээ шаардлагын талаар нарийн тодорхой ойлголтгүй байж болох юм. Үүнээс гадна, одоогийн эрсдэлийн үнэлгээний зааварт хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, эмэгтэйчүүд, хүүхдүүд зэрэг хамгийн эрсдэлтэй бүлгийн эмзэг байдлыг орхигдуулах, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын төлөвлөлтөд чухал ач холбогдолтой гамшгийн эрсдэлийн үнэлгээ, байгаль орчны эрсдэлийн үнэлгээ хоорондоо давхцах байдал гардаг байна.



### НЭН ЧУХАЛ, ТҮҮВЭР ЗӨВЛӨМЖҮҮД:

1.

ОБЕГ-ын болон орон нутгийн ОБГ-ын бие бүрэлдэхүүн хүлээсэн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд, түүнчлэн чадавх сайжруулах цаашдын хөтөлбөрүүдэд жишиг болгох үүднээс чиг үүргүүдийн хүрээнд шаардагдах үндсэн гол мэдлэг, ур чадваруудыг тодорхойлох.



2.

Сэрэмжлүүлэх мэдээллийг төрийн байгууллага, иргэдийн аль алиных нь бэлэн байдалтай уялдуулахын тулд системийн хэмжээний үйл ажиллагааны журам, протоколуудыг бий болгох. Хянах, ажиглах, таамаглах, сэрэмжлүүлэх мэдээллийг түгээх нь эрт зарлан мэдээлэх систем буюу "хүн амд шууд хүрэх" эрт зарлан мэдээлэх системийн нэг хэсэг юм.



3.

ОБЕГ, орон нутгийн засаг захиргаа, салбарын яамд гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанаас сэргээн босгох ажиллагаанд шилжихэд шаардлагатай үйл ажиллагааны журам, үүрэг хариуцлагыг тодорхойлох. Хүмүүнлэгийн ажиллагааны үндсэн стандарт SPHERE, түргэвчилсэн эхний үнэлгээ (IRA), салбар хоорондын түргэвчилсэн эхний үнэлгээ (MIRA), гамшгийн дараах хэрэгцээний үнэлгээ (PDNA), гамшгийн дараах сэргээн босгох ажиллагаа (DRF) зэрэг олон улсын стандарт, арга зүйг судлах.



## САНХҮҮЖИЛТ

Монгол Улс гамшгийн эрсдэлийг бууруулахад төсөв хуваарилж байгаа нь тодорхой ахиц дэвшлийг харуулж байгаа хэдий ч санхүүжүүлж буй арга хэмжээний төрөл, онцлог тодорхойгүй, гамшгийн эрсдэлийг бууруулах/уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ажиллагааны төсвийн ангилал нь төсвийн хуваарилалтыг нэмэгдүүлэхэд төдийлөн түлхэц болохгүй байна. Сөндайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийн дунд хугацааны тайлангаас үзэхэд гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн зардал 88.4%-иар, зудын бэлэн байдалд (өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх) шаардагдах зардал 9.2%-иар, улсын нөөцөөс зайлшгүй шаардлагатай бараа бүтээгдэхүүнээр хангах зардал 9.2%-иар өссөн байна. Гэвч Сүхбаатар, Увс аймагт зохион байгуулагдсан хэлэлцүүлгүүдээс харахад гамшгийн эрсдэлийг бууруулах дэд бүтцэд, тухайлбал, гал командын барилга байгууламж, холбооны хэрэгсэлд зарцуулах төсөв хангалтгүй байна. Чиг үүргийн байгууллага,

агентлагууд эрсдэлийг бодитой бууруулах үйл ажиллагаанд төсөв бүрдүүлэх хүндрэлтэй байдгийг хэлж байв. Төсвийн бодлого нь их хэмжээний зардал шаардаж болзошгүй гамшгийн нөхцөл байдлыг, тухайлбал барилга байгууламж нурж сүйдэн ДНБ-ий 25%-тай тэнцэх хэмжээний алдагдалд хүргэж болзошгүй газар хөдлөлт зэргийг тусгадаггүй байна. Монгол Улсын даатгалын салбар нь даатгалын шимтгэлийг илүү сайн тооцоолохын тулд эрсдэлийн мэдээллээ сайжруулах, ялангуяа гамшигт хамгийн их өртдөг боловч даатгалын шимтгэл төлж чадахгүй байгаа хүмүүсийг эрсдэлийн даатгалд хөрөнгө оруулахад нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна. Одоогоор Монгол Улс урьдчилан сэргийлэхэд буюу гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийхээс илүүтэй гамшгийн хор уршгийг арилгах ажиллагааг санхүүжүүлэхэд анхаарч байгаа бөгөөд гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийн иж бүрэн стратеги дутагдаж байна.

### НЭН ЧУХАЛ, ТҮҮВЭР ЗӨВЛӨМЖҮҮД:

1.

Гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор нэн чухал дэд бүтэц, барилга байгууламжийг засварлах, сайжруулахад; эрсдэлийн мэдээлэлд үндэслэсэн төлөвлөлт, бодлого боловсруулахад; хүн амд шууд хүрэх эрт зарлан мэдээллийн системд; судалгаа шинжилгээ, технологи, инженерийн шийдлийг хөгжүүлэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн буюу даван туулах чадавхыг бий болгоход зориулан төсвийн нийт хуваарилалтыг нэмэгдүүлэх.



2.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны санхүүжилтийг нэмэгдүүлэхийн тулд гамшгийн хохирлын талаарх түүхэн мэдээлэлд үндэслэн гамшгийн тодорхойлолт, хэмжих нэгжийг тодорхой болгох. Гамшиг тохиолдохоос өмнө бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээ авах замаар гамшгийн болон уур амьсгалын эрсдэлийг бууруулсны дараа үлдсэн эрсдэлийг шийдвэрлэхийн тулд эрсдэл шилжүүлэх механизмыг гамшгийн эрсдэлийг бууруулах ерөнхий санхүүжилтэд нэмэлтээр ашиглах хэрэгтэй.



3.

Эрсдэлийн талаарх одоогийн мэдлэг, мэдээлэл болон туршлагатай улс орнуудын сургамжид үндэслэн гамшигт нөхцөл байдлын төсөв, санхүүгийн бэлэн байдлыг тусгасан сэргээн босгох, сэргээн засварлах бүтцийг бий болгох. Төв Азийн эрсдэлийн сангийн механизмын талаарх яриа хэлэлцүүлгийг урагшлуулах нь стратегийн боломжит хувилбаруудын нэг юм.





## БАЙГАЛЬ ОРЧИН

Газар зүйн байрлал, цаг уурын онцлогоос шалтгаалан Монгол орон уур амьсгалын өөрчлөлтөд илүүтэй өртөж, усны нөөц, ой мод, бэлчээр, биологийн олон янз байдалд нөлөөлж байна. Монгол Улсад байгалийн төрөл бүрийн гамшиг тохиолдож байгаагийн 81% нь салхи, бороо, аянга цахилгаанаас үүдэлтэй бөгөөд эдгээр нь сүүлийн 20 жилийн хугацаанд хоёр дахин нэмэгджээ.

Ийм эмзэг байдалтай байгаа хэдий ч Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн тухай тусгай хууль, дасан зохицох тодорхой стратеги, эрсдэлийн үнэлгээний арга зүй байхгүй байна. Үүний зэрэгцээ, газар ашиглалт, нөөцийн менежменттэй холбоотой зохицуулалт муу байгаагаас тууштай бодлого явуулах, нэгдсэн шийдвэр гаргах боломжгүй байна. Монгол орны өргөн удам газар нутаг нь ойн бодлогыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг ч “Тэрбум мод” зэрэг санаачилга нь засаглалын шинэлэг боломж байгааг харуулж байна. Нөөцийг хянах, мэдээлж тайлагнах үйл явцад олон нийтийг оролцуулах журмыг боловсронгуй болгох нь ойн менежментийг сайжруулах боломжтой.

Засгийн газрын нөөц хязгаарлагдмал, салбар хоорондын үүрэг хариуцлага тодорхой бус байгаа нь уур амьсгалын асуудлаарх үндэсний болон орон нутгийн удирдлага хоорондын

зохицуулалтад нөлөөлж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг зөвхөн Байгаль орчны яамны хариуцах ажил гэж эндүүрэх нь нийтлэг байгаагаас энэ асуудлыг өргөн хүрээтэй бодлого, төлөвлөлтөд тусгахад саад болж байна. Санхүүгийн боломж бололцоо болон засаг захиргааны бүх түвшинд буй ашиг сонирхлын зөрчил нь эрсдэлийг бууруулах, уур амьсгалд дасан зохицох үйл ажиллагааны санхүүжилтийг хязгаарлаж байна. Одоогийн байдлаар байгаль орчны гамшигийн эрсдэлийн удирдлагын санхүүжилт нь гол төлөв гал түймрээс урьдчилан сэргийлэх, ус хамгаалах, бохирдлыг бууруулахад чиглэж байна. Гэсэн хэдий ч гамшигийн эрсдэл, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хүчин чармайлтыг илүү цогцоор нь хамруулахын тулд ногоон санхүүжилтийг өргөжүүлэх томоохон боломж бий.

1980-аад оноос хойш Монгол Улсын Ус, цаг уурын алба бэлчээрийн мониторингийн иж бүрэн тогтолцоог боловсруулсан бол одоо нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээгээр хангах чиглэлд ахиц дэвшил гаргаж байна. Гэвч газар ашиглалтын төлөвлөлт болон эдийн засгийн бусад салбарт уур амьсгалын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийхэд шаардлагатай өгөгдлийг боловсруулах чадавх дутагдалтай хэвээр байна.



### НЭН ЧУХАЛ, ТҮҮВЭР ЗӨВЛӨМЖҮҮД:

1.

Нийгэм, эрүүл мэнд, боловсрол зэрэг бүх салбарын үндэсний болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд уур амьсгалын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг тусгах



Засаглал

2.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаанд оролцож буй байгууллагуудын хүрээнд үүрэг, хариуцлагыг тодорхой болгох.



3.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр холбогдох бүх талуудын нөөцийг дайчилж, хүчин чармайлтыг нэгтгэн хууль сахиулах, бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх.



Хэрэгжилт

4.

Бодлого, төлөвлөлтөөс бодит хэрэгжилтэд шилжих, ялангуяа орон нутгийн нөөцийг стратегийн хувьд дайчлан эмзэг бүлгүүдийг дэмжих.



5.

Даатгалын хуульд сүүлийн үеийн хөгжил дэвшлийг тусгахын тулд даатгалын тогтолцооны зохицуулалтуудыг шинэчлэх, хөдөө орон нутгийн малчдын амьжиргааг дэмжих. Уг шинэчлэл нь малчдын хэрэгцээнд нийцүүлж тусгайлан боловсруулсан даатгалын шаардлагуудыг тусгасан байх хэрэгтэй.



Санхүүжилт

6.

Цаг агаарын мэдээнд онцлогт бэлэн байдлын шаардлагуудыг тусгах, олон нийтийн мэдээллийн хүртээмжийг хангах, байгаль орчны мэдээллийн найдвартай байдлыг сайжруулах.



Мэдлэг мэдээлэл, технологи

7.

Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн цаашдын төлөвт газрын хөрс, газар ашиглалтад хүлээгдэж буй өөрчлөлтийн талаарх мэдээллийг тусгах. Энэ алхам нь эрсдэлийн үнэлгээний нарийвчлал, үнэн зөв байдлыг дээшлүүлэх чухал ач холбогдолтой.



## ХӨДӨӨ АЖ АХУЙ

Хөдөө аж ахуйн салбар нь улс орны хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөөгийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ажлын байр бий болгох, үйлдвэрлэлийг материалаар хангах, улмаар эдийн засгийг төрөлжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Түүхээс харахад хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн салбар нь 1990-ээд оны эцэс хүртэл Монгол Улсын ДНБ-ий 40 хүртэлх хувийг бүрдүүлдэг эдийн засгийн гол хөдөлгөгч хүч байсан. Монгол Улсын эдийн засаг, соёлын өвтэй салшгүй холбоотой энэ салбар нь өнөөдөр ч ДНБ-д томоохон хувь нэмэр оруулсаар байна.

Гэвч хөдөө аж ахуйн салбарт уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалсан сорилтууд тулгарч байна. Монгол Улс зудын эрт сэрэмжлүүлэх системийг бий болгож, яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч гамшгаас хамгаалах цогц бэлэн байдал үгүйлэгдэж байна. Уур амьсгалын өөрчлөлт, байгалийн аюулт үзэгдлийн нөлөөг улам даамжруулж буй бэлчээрийн даац хэтрэлт, бэлчээрийн доройтлоос сэргийлэхийн тулд малын тоо толгойг бэлчээрийн даацтай уялдуулах нь нэн чухал юм. Махны экспортыг нэмэгдүүлэх нь энэ тэнцвэрийг хадгалахад стратегийн чухал ач холбогдолтой.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, тогтвортой хөгжил хоорондын уялдаа холбоог бодлогын баримт бичгүүдэд хүлээн зөвшөөрдөг ч тэдгээрийн практик хэрэглээ дутмаг ажээ. Ялангуяа зудаас бусад байгалийн гамшгийн бэлэн байдлын удирдлага хангалтгүй байна. Хүнсний ногооны салбар эрс тэс уур амьсгалаас шалтгаалаад маш их сорилттой тулгардаг бөгөөд бодлогын зорилтуудад эмзэг бүлгийн хүмүүсийн даван туулах чадавхыг сайжруулах талаар тодорхой зүйл тусгадаггүй байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд нотолгоонд суурилсан төлөвлөлт, уур амьсгалын санхүүжилтийн судалгаа шинжилгээг яаралтай хийх шаардлагатай.

Орон нутгийн ард иргэд, ялангуяа малчид, тариаланчид гамшгийн хариу арга хэмжээг төлөвлөх, хянах, үнэлэхэд бараг оролцдоггүйгээс гамшгийн эрсдэлийн талаарх ойлголт муутай байгаа нь даван туулах чадавхыг сайжруулах үр дүнтэй стратеги боловсруулахад сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн гамшгийн эрсдэлийн талаар дутуу дулимаг мэдлэгтэйгээс эрсдэл шилжүүлэх эсвэл даатгалын хувилбаруудыг судалж үзэхэд төдийлөн ач холбогдол өгдөггүй ажээ.



### НЭН ЧУХАЛ, ТҮҮВЭР ЗӨВЛӨМЖҮҮД:

1. Хөдөө аж ахуйн салбар дахь төлөвлөлтийн уялдаа холбоог сайжруулахын тулд хөдөө аж ахуй, онцгой байдлын удирдлага, байгаль орчин, нийгмийн болон хэрэглээний шинжлэх ухаан зэрэг холбогдох салбаруудын идэвхтэй үүрэг, оролцоог хангах.



Засаглал

2. Салбарын хөгжил, гамшгийн эрсдэлийг бууруулах талаар бодлого, шийдвэр гаргахад орон нутгийн иргэдийг идэвхтэй оролцуулах замаар засаглалын хүртээмжийг чухалчлах.



Хэрэгжилт

3. Орон нутгийн иргэдийн даван туулах чадавхыг сайжруулахын тулд өвс, тэжээлийн агуулах, боловсруулах байгууламж байгуулахад дэмжлэг үзүүлэх.



4. Даатгалыг илүү үр дүнтэй болгохын тулд цаг агаарт суурилсан газар тариалангийн даатгалын тогтолцооны тэргүүн туршлагыг судлах, хэрэгжүүлэх.



Санхүүжилт

5. Газар тариалан, хүнсний тариаланчдад зориулсан даатгалын тогтолцоог боловсруулж, тэдэнд чиглэсэн санхүүгийн хамгаалалтыг санал болгох.



6. Олон нийтийн даван туулах чадавхыг сайжруулахын тулд хөдөө аж ахуйн салбарт гамшгийн эрсдэлийг бууруулах/удирдах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох тухай олон нийтийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх.



Мэдлэг мэдээлэл, технологи

7. Гамшгийн нөлөөлөл, хариу арга хэмжээний стратегийн үр нөлөөг хянах хэмжүүр, үзүүлэлтүүдийг бий болгох.



## ҮЕРЭЭС ХАМГААЛАХ ДЭД БҮТЭЦ

Үерээс хамгаалах дэд бүтцийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд засаг захиргааны хил хязгаарыг давсан цогц зохицуулалт, тогтвортой санхүү, хөрөнгө оруулалт шаардлагатай. Гэтэл одоогийн хууль эрх зүйн болон зохион байгуулалтын тогтолцоогоор үерийн менежментийн энэ цогц үйл ажиллагааг төдийлөн дэмжиж чаддаггүй бөгөөд орон нутгийн засаг захиргаа нь хот төлөвлөлт, усны нөөцийн менежментийн хүрээнд үерээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн үүргийг хүлээдэг.

Нийслэлийн Геодези, усны барилга байгууламжийн газар нь боловсон хүчин дутмаг хэдий ч үерийн эрсдэлийн шинжилгээ, инженерийн шугам сүлжээний ажил хийх техникийн чадавхтай. Гэвч

хотын үерээс хамгаалах хүчин чармайлтад, түүний дотор хуучирсан дэд бүтцийн засвар үйлчилгээ, ус зайлуулах системийн цэвэрлэгээнд санхүүжилт хангалтгүй, шаардлагатай төсвийн зөвхөн 10 орчим хувийг л авдгаас үйл ажиллагаа нь доголдож байна.

Хөрөнгө оруулалтын тогтвортой стратеги байхгүйгээс урт хугацааны төлөвлөгөөнүүд хэрэгжих боломжгүй байна. Дэд бүтцийн шийдлүүдэд үерийн эрсдэлийн мэдээлэл, технологийг тусгаж байгаа ч хот орчмын болон албан бус суурьшлын бүсийн иргэдийн эмзэг байдлыг эрсдэлийн загварчлал зохих ёсоор шийдэж чадахгүй байх магадлалтай.



### НЭН ЧУХАЛ, ТҮҮВЭР ЗӨВЛӨМЖҮҮД:

1.

Үерийн менежментэд тохирсон усны менежмент, хамгаалалтын элементүүдийг тусган Усны тухай хуулийг сайжруулах.



2.

Хүний нөөцийг тоо, чанарын хувьд системтэй нэмэгдүүлэх замаар үерээс хамгаалах дэд бүтцийн хэрэгжилтийг эрчимжүүлэх. Үерийн менежментийн урт хугацааны мастер төлөвлөгөөний санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан хүний нөөцийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг дор хаяж 3-5 жилийн хугацаатай боловсруулах.



3.

Уур амьсгалын ногоон сан, Монгол Улс дахь магадлан итгэмжлэгдсэн санхүүгийн компаниуд болон олон улсын байгууллагуудаас уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр санхүүжилтийн дэмжлэг авах хувилбаруудыг судлах.



Засаглал

Хэрэгжилт

Санхүүжилт

## СУРГУУЛЬ, ЭМНЭЛЭГ

Холбогдох хууль тогтоомжийн дагуу Боловсрол, шинжлэх ухааны яам нь сургуулийн дэд бүтцэд хяналт тавьдаг бол Эрүүл мэндийн яам нь эрүүл мэндийн байгууламжуудыг удирдан чиглүүлдэг байна. Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төвөөс барилгын норм стандартыг тогтоодог. Монгол Улс 1950-иад онд тухайн үеийн ЗХУ-ын архитектур, хот байгуулалтын норм дүрмийг ашиглаж эхэлснээс хойш барилгын норм дүрмээ шинэчилж, газар хөдлөлтийн хүчин зүйлүүдийг тусгаж байна.

Сургуулиудын ихэнх нь (88%) гамшгийн эрсдэлийг бууруулахад зориулагдсан төсөвгүй, 80% нь онцгой байдлын үед боловсролын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх тусгайлсан хөрөнгөгүй, барилгын насжилт, нөхцөл байдал эсвэл аюулд өртөх байдлыг нь харгалзан засах, сайжруулах ажлыг эрэмбэлэх тодорхой шалгуургүй байна.

Сургуулийн барилгуудыг сайжруулах, хүчитгэх ажил зохих заавар чиглэл, хөрөнгө санхүү байхгүйгээс саатжээ. Газар хөдлөлтийн эрсдэлийн мэдээлэл, тухайлбал 2013 онд ЖАЙКА-гийн төслөөс Улаанбаатар орчмын газар хөдлөлтийн хоёр хувилбарыг тооцоолсон зэрэг зарим мэдээллүүд байдаг байна.

Сургууль, эмнэлгийн барилгуудад хийсэн газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээгээр уг барилгуудад хохирол учирч болзошгүй ихээхэн эмзэг байдалтай байгаа нь газар хөдлөлтийн дараа боловсролын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад бэрхшээлтэй болохыг харуулж байна. Гэсэн хэдий ч эдгээр салбарын өнөөгийн стратеги нь гамшгийн эрсдэлийг бууруулахад анхаарал бараг хандуулдаггүй, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах асуудлыг нэн тэргүүнд тавьдаг байна.



### НЭН ЧУХАЛ, ТҮҮВЭР ЗӨВЛӨМЖҮҮД:

1.

Улаанбаатар хот газар хөдлөлтийн өндөр эрсдэлтэй тул нийслэлийн барилга байгууламжийг бэхжүүлэх нь гамшгийн эрсдэлийг бууруулах гол арга хэмжээ гэж үзэн боловсролын салбарын төлөвлөлтөд тусгах.



Засаглал

2.

Газар хөдлөлтийн сүүлийн үеийн нөхцөл байдалд үндэслэн Улаанбаатар хотын бүх сургууль, эмнэлгийн барилгуудад барилгын бүтцийн эрсдэлийн үнэлгээг хийх.



Мэдлэг мэдээлэл, технологи

3.

Сургууль, эмнэлгийн барилга байгууламжийг хүчитгэхэд чиглэсэн эрсдэлийг бууруулах дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг яамдууд тусгайлан боловсруулах.



Санхүүжилт

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД БҮТЭЦ

Эрчим хүчний салбарын гамшгийн эрсдэлийг бууруулах чиг хандлага нь социализмын үеийн иргэний хамгаалалтаас эхтэй, туршлагатай хүн хүч, онцгой байдлын үеийн хангамж, техник хэрэгсэл бүхий цогц, олон талт ажиллагаа байдаг. Эрчим хүчний яам нь эрчим хүчний бодлого, стратеги, хяналтад чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд эрчим хүч үйлдвэрлэх, сүлжээ хөгжүүлэх, төвлөрсөн дулаан хангамж зэрэг олон төрлийн үйл ажиллагааг удирдаж, нүүрс болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт анхаарал хандуулан ажилладаг байна. 2023 онд Эрчим хүчний яамнаас Салбарын хяналтын газрыг байгуулж, Засгийн газраас баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу салбарын анхны эрсдэлийн үнэлгээг хийсэн нь эрсдэлийн удирдлагыг сайжруулахад чухал алхам болсон юм. Мөн Онцгой байдлын ерөнхий газартай хамтран гал түймрийн эрсдэлийн үнэлгээ хийсэн нь тус салбар эрсдэлийн удирдлагын талаар тууштай ажиллаж байгааг болон гамшгийн бэлэн байдал, тэсвэрлэх чадавхыг сайжруулах чиглэлд идэвхтэй байр суурь баримталж байгааг батлан харуулжээ.

Гэвч эрчим хүчний салбарын гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, Онцгой байдлын ерөнхий газар, орон нутгийн Онцгой байдлын газрууд болон бусад гол байгууллагуудтай

уялдаа холбоо багатай байгаа нь гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг зохицуулалтгүй, үр дүн багатай болгож болзошгүй юм. Эдгээр төлөвлөгөө нь гамшгийн янз бүрийн нөхцөл байдалд байгууллага болон ажилтнуудын бэлэн байдлыг хангах нарийвчилсан стратегийг тусгаагүй тул хор уршгийг арилгах шуурхай ажиллагааны удирдамж заавар дутуу, дэд бүтэц, бие бүрэлдэхүүний эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Эрчим хүчний салбарын гамшгийн эрсдэлийн менежментийн ахиц дэвшилд хэд хэдэн чухал сорилт саад болж байна. Тухайлбал, шуурхай ажиллагааны багийн бие бүрэлдэхүүн хүрэлцээгүй байгаа нь гамшгийн үед салбарын хариу арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх чадавхад нөлөөлнө. Үүнээс гадна, хуучирсан дэд бүтцийн техникийн шинэчлэлд болон хувьсан өөрчлөгдөж байгаа гамшгийн эрсдэл, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд дасан зохицоход зайлшгүй шаардлагатай судалгааны ажлуудад санхүүжилт нилээд дутагдалтай байна. Хөгжүүлэлт, засвар үйлчилгээний төлөвлөгөөнд гамшгийн эрсдэлийн мэдээллийг ихэнхдээ орхигдуулдаг нь цахилгааны тулгуур багана, уурын хоолой зэрэг салбарын дэд бүтцийн эмзэг байдлыг бий болгож, аюулгүй байдалд нөлөөлнө.

### НЭН ЧУХАЛ, ТҮҮВЭР ЗӨВЛӨМЖҮҮД:

1.

Дэд бүтэц, орон нутгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах, тэсвэрлэх чадавхыг сайжруулахын тулд гамшгийн эрсдэлийн удирдлага, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг хөгжлийн бүх төлөвлөгөө, бодлогод тусгах.



Засаглал

2.

Салбарын нэн чухал дэд бүтэц, байгууламжуудын зураглал, бүртгэлийг гаргаж, төрөл бүрийн гамшгийн нөхцөл байдлын үед аюулгүй байдлыг нь эн тэргүүнд хангах.



Хэрэгжилт

3.

Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлийн судалгаа, хөгжүүлэлтийн ажилд төсөв тогтмол хуваарилах.



Санхүүжилт

4.

Дэд бүтцийн бүсэд гамшгийн онцлогтой эмзэг цэгүүдийг тодорхойлж, эрсдэлийг хянах мэдрэгч эсвэл тоолуур суурилуулах.



Мэдлэг мэдээлэл, технологи

## ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Газарзүйн өвөрмөц байршилтай, мал аж ахуй эрхэлдэг Монгол орон ус, цаг уурын гаралтай гамшиг, аюулт үзэгдэлд улам бүр эмзэг байдалтай болж байгаа нь хүн амын шилжилт хөдөлгөөнд нөлөөлж байна. Дотоодын урт, богино хугацааны шилжилт хөдөлгөөний аль аль нь ач холбогдолтой боловч богино хугацааны (3 сараас доош) шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл хомс байна. 1992 оноос шилжилт хөдөлгөөн эрх зүйн хувьд чөлөөтэй болсон; уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн байгалийн гамшиг олонтоо тохиолдож, малын хорогдол нэмэгдэх болсон; хот, хөдөөгийн дэд бүтцийн ялгаа ялангуяа эрүүл мэнд, боловсролын салбарт ихсэх болсон зэрэг үндсэн гурван хүчин зүйлээс шалтгаалж, хөдөөнөөс Улаанбаатар болон бусад хот суурин газар руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгджээ. Нийслэл Улаанбаатар хот нь Монгол Улсын хоёр дахь том хотоос харьцангуй том бөгөөд одоо 1.5 сая гаруй хүн буюу хүн амын 45.9% нь амьдарч байна. Хүн амын энэ их нягтрал нь байгаль орчны бохирдол, түгжрэл, төрийн үйлчилгээний хэт ачаалал, ядуурал ихтэй “гэр хороолол”-ын тэлэлтэд хүргэж, хот доторх шилжилт хөдөлгөөний эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Монгол Улс нь гамшгийн эрсдэлийг бууруулах засаглалын тогтолцоо сайтай бөгөөд гэнэтийн гамшигтай тэмцэх үүрэг, хариуцлагыг сайтар тодорхойлжээ.

Энэхүү тогтолцоо нь улс төрийн дэмжлэг бүхий гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хэмжээний бүтэцтэй. Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хэдийгээр шилжилт хөдөлгөөний урсгалыг хянах зорилготой боловч зориуд бусаар эмзэг байдал, тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна. Монгол Улсын гамшгийн эрсдэлийг бууруулах, дасан зохицох төлөвлөгөөнүүдэд хүн амын шилжилт хөдөлгөөнийг тусгахдаа гэнэтийн шилжилт хөдөлгөөнд ач холбогдол өгснөөс удаан өрнөлттэй үйл явдал, урт хугацааны шилжилт хөдөлгөөний шийдлүүдэд анхаарал бага хандуулсан байна. Дэд бүтцийн өнөөгийн чадавх нь дунд болон их хэмжээний шилжилт хөдөлгөөний үед хариу арга хэмжээ авахад хангалтгүй тул шилжилт хөдөлгөөн хийж буй эмзэг бүлэг, иргэдийн хамгааллыг сайжруулах чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн болон олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах нь тогтолцооны хувьд ашигтай.

Монгол Улс 2020 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого зэрэг хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хэд хэдэн чухал бодлого, хуулийг санаачилсан. Гэвч дотоодын шилжилт хөдөлгөөнийг системтэйгээр зохицуулах тусгайлсан бодлогууд нь учир дутагдалтай хэвээр байна.

### НЭН ЧУХАЛ, ТҮҮВЭР ЗӨВЛӨМЖҮҮД:

1.

Шилжилт хөдөлгөөний асуудлыг тусгасан бодлого, төлөвлөгөөг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд уг асуудлыг шийдвэрлэх тогтолцоотой болох, нөөц илүү хуваарилах шаардлагатай байна. Үүнд үндэсний хэмжээнд, хотын болон орон нутгийн түвшинд, ялангуяа Улаанбаатар хотын захиргаанд шилжилт хөдөлгөөн, шилжигсдийн асуудлыг зохицуулах агентлаг, хэлтэс, нэгж байгуулах асуудал орж болох юм.



Засаглал

2.

Шилжигсдийг хүлээн авч буй бүс нутгийн одоо, ирээдүйн газар ашиглалт, хөгжлийн төлөвлөлтийг тооцох, цаашдын нөхцөл байдлыг загварчлах, бүтээн байгуулалтын иж бүрэн төлөвлөлтийг хэрэгжүүлэхийн тулд газрын боломж, давуу талыг ашиглах тогтолцоог бий болгох.



Хэрэгжилт

3.

Илүү тогтвортой, найдвартай санхүүжилтийн тогтолцоог судалж, бий болгох нь гамшгийн бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, мөн гамшгийн үеийн шилжилт хөдөлгөөний төлөвлөлтөд ихээхэн дэмжлэг болно.



Санхүүжилт

4.

Оршин суух бүртгэлийг дараах байдлаар шинэчлэх, сайжруулах. Үүнд: үл хөдлөх хөрөнгийн өмчлөл, түрээсийн баримт нотолгоог багасгах, шилжигсдийг өөрсдийн байршлын талаар засаг захиргаанд үнэн зөв, цаг тухайд нь мэдэгдэхэд түлхэц өгөх; онлайн бүртгүүлэх боломжтой байх; шилжин суурьшигсдыг нийслэлд ирмэгцээ бүртгүүлэхийг дэмжсэн аян хэрэгжүүлэх.



Мэдлэг мэдээлэл, технологи

5.

Монгол орны нөхцөл байдалд тохируулан өвөлжилтөд шаардлагатай зүйлсийг нэмж нөөцлөх, урьдчилан байршуулахад хөрөнгө оруулах. Өвөлжилтийн уламжлалт болон уламжлалт бус аргуудыг судлах.



## НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Нийгмийн хамгаалал нь гамшгийн, түүний дотор уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй аюулт үзэгдлийн улмаас эмэгтэйчүүд, хүүхэд, өндөр настан зэрэг эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх нөлөөллийг бууруулан Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улсын хүн амын багагүй хэсэгт, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, хүүхдүүдэд гамшгийн үед нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байдаг. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь нийгмийн хамгааллын салбарт гамшгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, онцгой байдлын үеийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, шаардлагатай дүрэм журмыг боловсруулах үүрэг хүлээсэн. Гэвч хууль эрх зүйн болон бодлогын цогц зохицуулалт байхгүйгээс гамшгийн үед эрсдэлт бүлгийн эмзэг байдлыг багасгах талаар тодорхой арга хэмжээ авах, гамшгийн эрсдэлийг үр дүнтэй бууруулах тусгай заавар, стандарт боловсруулагдаагүй байна.

Салбаруудын хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтуудыг зохион байгуулж байгаа хэдий ч нийгмийн хамгааллын салбарын онцлогт тохируулан чадавхыг бэхжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, КОВИД-19 цар тахлын үед нийгмийн хамгааллын салбарын ажилтнууд үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлах, эмзэг бүлгийнхэнтэй үр дүнтэй харилцах, үйл ажиллагааны протоколуудыг дагаж мөрдөх чиглэлээр хүндрэл бэрхшээлтэй тулгарсан. Гамшгийн үед хүмүүсийн хэрэгцээг тодорхойлох түргэвчилсэн үнэлгээний хэрэгсэл байхгүй, онцгой байдлын үеийн бүртгэлийн цогц систем байхгүй байгаа нь хямралын үед хэрэгцээт хүмүүст нь илүү сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд шаардлагатай дүрэм журмуудыг боловсруулах, бэлэн байдлын стратегийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

### НЭН ЧУХАЛ, ТҮҮВЭР ЗӨВЛӨМЖҮҮД:

1.

Нийгмийн хамгааллын удирдлага, стратегид олон улсын хүмүүнлэгийн стандартыг тусгах, сайжруулах.



Засаглал

2.

Хүмүүнлэгийн хариу арга хэмжээний олон улсын стандартыг өнөөгийн тогтолцоонд нийцүүлэн хэрэгжүүлэх.



Хэрэгжилт

3.

Гамшгийн дараа иргэдэд олгох нэг удаагийн тэтгэмжийн хэмжээг уян хатан болгож, учирсан хохирол, эмзэг байдлын түвшинд тохируулах.



Санхүүжилт

4.

Гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоог бүх түвшинд бэхжүүлж, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт тавих, гамшгийн үед эмзэг бүлгийн иргэдэд онцгой анхаарал хандуулж, санал хүсэлтийг хангах.



Мэдлэг мэдээлэл, технологи





UNITED NATIONS  
MONGOLIA



**caDRi**  
**Partnership**  
Capacity for Disaster  
Reduction Initiative